



УВС ЧАЦАРГАНА ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны _04_ сарын _30_ өдөр

Дугаар _11/25_

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“Увс чацаргана” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 13.00 цагт Улаанбаатар хот БГД 26 хороо “Эн Би Би Ди” ХХК байр 1 давхар 1 тоотод болов.

Хуралд:

“Увс чацаргана” ХК нь нийт 567,811 ширхэг хувьцаатайгаас хуралд хувьцаа эзэмшигч:

С.Батболд/ 282450 ширхэг хувьцааны саналаар/

Д.Эрдэнэ /285319 ширхэг хувьцааны саналаар/

тус тус өөрийн биеэр оролцов.

Хурал зохион байгуулах комисс хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хийж компанийн нийт гаргасан 567,811 хувьцаанаас саналын эрхтэй хувьцааны тоог 567,769 ширхэг хувьцаагаар тогтоож хурлын ирц 99,9 хувьтай байгааг мэдээлж компанийн тухай хуулийн 69.1 заасны дагуу хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлыг эхлүүлэхийг тооллогын комисс зөвшөөрөв.

Хурал 13 цаг 10 минутанд эхлэв.

Хурал зохион байгуулах комиссын дарга А.Ариунсайн үг хэлэв.

-Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Компанийн ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай тогтоолд хурлыг удирдах даргаар Д. Эрдэнийг томилсон иймээс хурлын дарга хурлыг эхлүүлнэ үү.

Ингээд хурлын дарга Д.Эрдэнэ байраа эзлэв.

- За та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Миний бие Увс чацаргана ХК-ийн ТУЗ дарга хувьцаа эзэмшигч Эрдэнэ гэдэг Ингээд хуралаа эхлэх үү. Хурлын дэгийг юуны өмнө уншиж танилцуулая.

Энэхүү хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ.

Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт ;
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах:
3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох :
4. Бусад асуудал:

СОНССОН НЬ 1:

Хурлын хэлэлцэх асуудлын дагуу 2024 оны үйл ажиллагааны тайлан болон компанийн товч танилцуулгыг уншиж танилцуулав. /Presentation/- ээр танилцуулга хийв.

“Увс чацаргана” ХК нь 1978 оноос хойш чацарганы үйлдвэрлэл эрхлэхээр байгуулагдсан бөгөөд 1988 он гэхэд нийт 480 га талбайд 500,000 ширхэг чацарганы модтой, бүрэн механикжсан усалгааны систем, үерийн далангийн байгууламжтай, нийт 300-аад ажиллагсадтай эрдэм шинжилгээний туршилт судалгааны төв болон өргөжсөн юм.

Монгол улс зах зээлийн нийгэмд шилжсэн 1990-ээд оны үед тус байгууллага нь бусад аж ахуйн нэгж, үйлдвэрүүдийн нэгэн адил зах зээлийн болон санхүүгийн хямралд өртөж их хэмжээгээр сүйдсэн юм.

Манай компани нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

1. Чацарганы аж ахуй
2. Мод үржүүлэг
3. Төмс, хүнсний ногоо тариалалт
4. Загас үржүүлэг, худалдаа зэрэг салбарт бизнесийн үйл ажиллагаа явуулж байна.

Шинэчлэгдсэн компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь чацарганы аж ахуй юм.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга А.Ариунсайн Компанийн тухай хуульд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ноогдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг ТУЗ гаргана гэж заасны дагуу ТУЗ хуралдаж компани (4 877 319) төгрөгийн алдагдалтай ажилласан тул хувьцаа эзэмшигчдэд ноогдол ашиг хуваарилах боломжгүй гэж үзсэн.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.
2. Компани 2024 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулсаныг дурьдсугай.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхижүүлж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

Хурал 14.30-д өндөрлөв.



ХУРАЛ УДИРДСАН:

ХУРЛЫН ДАРГА

Д.Эрдэнэ

/Д.ЭРДЭНЭ/

ПРОТОКОЛ БИЧСЭН:

Ариунсайн

/АРИУНСАЙН/